

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл Ус суваг” ХХК -ийн 2023 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХӨА-2024/08/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Хөвсгөл аймаг  
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:  
А.Эрдэнэбаатар  
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх  
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

“Бэйкир Тилли Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн  
Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

“Бэйкир Тилли Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн  
Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.СҮХБАТ ТАНАА**

### **Хараат бус аудиторын дүгнэлт**

#### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд 42,530.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитаар нийт 66,757.0 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс авлага, цалин, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой 73,593.1 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал 2023 оны бизнес төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан, хэрэгжүүлж ажилласан байна.

Тус компанийн удирдлага болон нягтлан бодогч тайлангийн хугацаанд солигдсон, удирдлага гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	178,807,331.18	19,857,477.74
1.1.2	Дансны авлага	195,691,314.23	266,052,280.15
1.1.6	Бараа материал	388,823,784.89	531,587,284.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	93,831,636.37
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>763,322,430.31</b>	<b>911,328,679.06</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,275,325,597.97	5,011,058,057.76
1.2.2	Биет бус хөрөнгө	3,645,639,113.74	3,634,328,678.82
1.2.9	Дуусаагүй барилга	9,475,600,265.45	9,475,600,265.45
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>18,396,564,977.16</b>	<b>18,120,987,002.03</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,159,887,407.47</b>	<b>19,032,315,681.09</b>
2.1.1.1	Дансны өглөг	8,870,451.14	17,419,712.01
2.1.1.3	Татварын өр	259,843.41	88,402,306.66
2.1.1.6	Хүүний өглөг	544,149,712.46	544,149,712.46
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,114,604.21	572,063.12
2.1.1.11	НДШ-ийн өглөг	35,948,868.73	
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>590,343,479.95</b>	<b>650,543,794.25</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	11,352,891,846.29	11,352,891,846.29
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>11,352,891,846.29</b>	<b>11,352,891,846.29</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>11,943,235,326.24</b>	<b>12,003,435,640.54</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>2,245,880,669.67</b>	<b>2,245,880,669.67</b>
2.3.1	төрийн	2,245,880,669.67	2,245,880,669.67
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	657,840,694.47	657,840,694.47
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,831,314,136.04	5,834,858,652.54
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,518,383,418.95	-1,709,699,976.13
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>7,216,652,081.23</b>	<b>7,028,880,040.55</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,159,887,407.47</b>	<b>19,032,315,681.09</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,468,525,226.47	3,570,473,896.95
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,238,778,312.51	3,475,922,031.06
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>229,746,913.96</b>	<b>94,551,865.89</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	219,376,483.57	285,868,500.98
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-9,775,464.21	0.00
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>594,966.18</b>	<b>-191,316,635.09</b>
19	Орлогын татварын зардал	59,496.62	0.00
<b>20</b>	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>535,469.56</b>	<b>-191,316,635.09</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>535,469.56</b>	<b>-191,316,635.09</b>
<b>24</b>	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>535,469.56</b>	<b>-191,316,635.09</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>4,071,942,675.16</b>	<b>3,821,516,828.44</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,877,543,787.41	3,782,042,205.32
1.1.6	Бусад мөнгөн орлого	194,398,887.75	39,474,623.12
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,753,683,824.51</b>	<b>3,969,469,981.88</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,381,818,922.38	1,569,966,165.60
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	347,684,399.94	481,861,452.47
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	377,626,675.58	504,908,461.89
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	650,666,471.35	768,982,295.60
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	236,941,418.10	178,243,336.97
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	411,591,951.60	244,278,264.09
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,451,150.00	5,500,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	340,902,835.56	215,730,005.26
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>318,258,850.65</b>	<b>-147,953,153.44</b>
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>344,932,996.92</b>	<b>10,996,700.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	325,132,996.92	10,996,700.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,800,000.00	0.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-344,932,996.92</b>	<b>-10,996,700.00</b>
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-26,674,146.27</b>	<b>-158,949,853.44</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>205,481,477.45</b>	<b>178,807,331.18</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>178,807,331.18</b>	<b>19,857,477.74</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эзэм/өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,245,880,669.67</b>	<b>657,840,694.47</b>	<b>5,321,717,899.7</b>	<b>-1,517,592,323.04</b>	<b>6,707,846,940.8</b>
Залруулсан үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,321,717,899.7	-1,517,592,323.04	6,707,846,940.8
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	535,469.56	535,469.56
Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	509,596,236.34	-1,326,565.47	508,269,670.87
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,245,880,669.67</b>	<b>657,840,694.47</b>	<b>5,831,314,136.04</b>	<b>-1,518,383,418.95</b>	<b>7,216,652,081.23</b>
Залруулсан үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,831,314,136.04	-1,518,383,418.95	7,216,652,081.23
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	-191,316,635.09	-191,316,635.09
Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.	0.	0.	0.
Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	3,544,516.5	0.	3,544,516.5
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,245,880,669.67</b>	<b>657,840,694.47</b>	<b>5,834,858,652.54</b>	<b>-1,709,700,054.04</b>	<b>7,028,879,962.64</b>

## 2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

	Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	2023 гүйц/ 2023 төл
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>	<b>3,947,274.4</b>	<b>3,525,455.7</b>	<b>89.3</b>
	Халаалтын орлого	830,562.3	718,139.9	<b>95.8</b>
	Цэвэр, бохир усны орлого	2,649,634.7	2,340,288.6	<b>88.3</b>
	Татаас	467,077.4	467,027.2	<b>99.8</b>
2	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>3,947,274.4</b>	<b>3,525,455.7</b>	<b>89.3</b>
3	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>4,579,785.3</b>	<b>3,716,772.3</b>	<b>81.2</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	295,185.0	285,868.5	<b>96.8</b>
4	Татварын өмнөх ашиг	(1,099,588.3)	(658,394)	<b>59.8</b>
5	Цэвэр ашиг /алдагдал/	(632,510.9)	(191,316.6)	<b>30.2</b>
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>603,217.9</b>	<b>460,289.6</b>	<b>76.3</b>
	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	10,410.5	9,740.5	<b>93.5</b>
	Нэмэгдсэн өртгийн албан татвар	235,000.0	145,258.8	<b>61.8</b>
	Ус ашигласны төлбөр	4,912.5	4,912.5	<b>0.0</b>
	Газрын төлбөр	9,816.2	10,104.6	<b>102.9</b>
	Агаарын бохирдлын төлбөр	58.9	58.9	<b>0.0</b>
	Тээврийн хэрэгслийн татвар	1,312.2	793.8	<b>60.5</b>
	ЭМНДШ	254,816.4	229,804.1	<b>90.2</b>
	Үл хөдлөхийн татвар	40,302.2	12,651.9	<b>31.4</b>
	ХАОАТ	46,589.0	46,964.5	<b>100.8</b>
	Бусад	-		
7	Нийт ажиллагсдын тоо	145	145	<b>100</b>
8	Нийт цалингийн сан	1,926,886.2	1,853,188.3	<b>84.2</b>
9	Нэг ажилтны дундаж цалин	977.8	947.6	<b>84.2</b>
10	<b>НИЙТ АВЛАГА</b>	<b>115,000.0</b>	<b>266,052.3</b>	<b>231.4</b>
11	<b>НИЙТ ӨГЛӨГ</b>	<b>11,590,343.0</b>	<b>12,003,435.6</b>	<b>170.7</b>
	Үүнээс: Богино хугацаат	590,343.0	650,543.8	<b>110.2</b>
	Урт хугацаат өр төлбөр	11,352,891.8	11,352,891.8	<b>100.0</b>

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн 1,707.5 мянган төгрөгийг, орлого дутуу тайлагнасан 49,588.3 мянган төгрөгийг залруулахаар 2 алдаа<sup>2</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа 1:

Биет бус хөрөнгөд элэгдэл тооцож бүртгэсэн 1,707.5 мянган төгрөгийн гүйлгээг засахдаа эзэмшигчийн өмчийн бусад хэсэг данснаас хассан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “*Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна*”, НББОУС 8-ийн 41 дүгээр параграф “*Санхүүгийн тайлан нь материаллаг алдааг эсвэл аж ахуйн нэгжийн санхүүгийн байдлын, үр дүнгийн, мөнгөн гүйлгээний тухайлсан тодорхой нэг толилуулгад хүрэхийн тулд санаатайгаар хийсэн*”

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

*материаллаг бус алдааг агуулж байвал СТОУС-тай үл нийцнэ” гэсэн заалтыг зөрчсөн ба “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Залруулсан алдаа 2:

Худаг, усан сангаар түгээсэн цэвэр усны орлого 49,588.3 мянган төгрөг мянган төгрөгийг бүртгэл тайланд тусгахгүйгээр зарцуулсан байна. Энэ нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.5 “*бүх орлого*” гэсэн заалтыг зөрчсөн ба “*иж бүрэн байх*” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 153,047.7 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>3</sup> илэрснээс авлага, цалин, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой 66,757.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 86,290.7 мянган төгрөгийн нийцлийн аудиттай холбоотой зөрчил илэрч 70,727.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

### **3.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт байхгүй болно.

### **3.2 Албан шаардлага**

Шилэн дансанд 6 мэдээлэл хугацаа хоцроож, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 70,727.2 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр 4.1.3-т “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 4.1.1-т “*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*”, 6 дугаар зүйл 6.4.4-д “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*”, Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “*Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам*”-ын 2.2.2.5-д “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*” зэрэг хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь “*нийцсэн бөгөөд зохистой*” байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой

*Илрүүлэлт:* Тайлангийн хугацааны эцэст 27,304.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 -т “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж байх*”, 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн*

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ба "нийцсэн бөгөөд зохистой" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлаг өглөгийн тооцоонд хяналт тавьж , авлага барагдуулах ажлыг хийц гүйцэтгэх.

2.Бараа материалын данстай холбоотой

*Илрүүлэлт:* 35,174.2 мянган төгрөгийн бараа материалыг ангилал буруу бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.7 "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэсэн заалтыг зөрчсөн ба "ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: 2024 оны 2 улиралд багтаан бараа материал хөрөнгийн ангиллыг залруулах

3.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дансанд нийт 66 нэр төрлийн 336,843.4 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолын 7.1."Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалтыг зөрчсөн ба "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС 17 дагуу үндсэн хөрөнгийг 3-5 жил тутамд дахин үнэлгээ хийлгэх буюу актлаж устгах шийдвэрийг гаргуулж байх.

4.Цалингийн тооцоололтой холбоотой:

*Илрүүлэлт:* Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингаас 3,937.1 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тооцсон суутгасан, амралтын 5 хоногийг олгоогүй 1,341.6 мянган төгрөгийн амралтын мөнгийг дутуу олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна", 144 дүгээр зүйлийн 144.7-д "Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй", ХХОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2.-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого"-ыг албан татвараас чөлөөлнө" гэсэн заалтыг зөрчсөн ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцооллыг зөв хийж холбогдох тайлангуудтай тулган шалгах

5.Биет бус хөрөнгөтэй холбоотой:

**Илрүүлэлт:** Компанийн эзэмшилд байгаа газрын судалгааг авч хянахад газар эзэмших эрхийн бүртгэлд талбайн хэмжээг бичээгүй, 47980,5м.кв талбай бүхий газар эзэмших эрхийн үнэлгээ 15,563.5 мянган төгрөгийн зөрүүтэй, 17,048м.кв талбай бүхий 14 газар бусдын эзэмшилд шилжүүлсэн газрыг бүртгэлээс хасаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр 71.1.1-д “үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх”, Засгийн газрын 2018 оны 182-р тогтоолын 4 дүгээр хавсралтын "Хот, тосгон, бусад суурины 1 га газрын суурь үнэлгээ", Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 10-р тогтоолын 7 дахь заалт зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй нь “нийцсэн бөгөөд зохистой” байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Газар эзэмших эрхийн бүртгэлийг санхүүгийн тайланд үнэн зөв, бодитой тусгах зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дансны бичилт буруу хийгдсэн	1	1,707.5			1	1,707.5	1	1,707.5				
Орлого дутуу тайлагнасан	1	49,588.2			1	49,588.2	1	49,588.2				
Дүн	2	51,295.7			2	51,295.7	2	51,295.7				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн суутгал буруу тооцож суутгасан	1	5,278.7					1	5,278.7
Тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө	1	-					1	
Авлагын үлдэгдэл баталгаажуулаагүй	1	27,304.1					1	27,304.1
Хөрөнгө, бараа материалын ангилал буруу бүртгэсэн	1	34,174.2					1	34,174.2
Дүн	4	66,757.0					4	66,757.0

## Нийцлийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	ажилтан	Тоо	Дүн
Шилэн дансанд 7 мэдээлэл хугацаа хоцроосон 2 мэдээ мэдээлээгүй байна.	1	70,727.2			1	70,727.2						
Газар эзэмших эрхийн бүртгэл зөрүүтэй.	1	15,563.5					1	15,563.5				
Дүн	1	86,290.7				70,727.2	1	15,563.5				

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таагласан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
2	Төсөл, хөтөлбөр									
3	ЗГТС									
4	ТТЗ									
5	ТЕЗ									
	НИЙТ	1	1			1				